# САНХҮҮ БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
| | | | | | Эхний хагас жил | Сүүлийн хагас жил | | |
| **НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ** | | | | | | | | |
| Нийгмийн даатгалын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын төв, орон нутгийн нэгжийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын дунд хугацааны төсвийн төсөл, төсөөлөл болон төсвийн нарийвчилсан хуваарийн санал боловсруулах, гүйцэтгэлд хяналт тавих, судалгаа хийх, иргэдийн төлөв байдал, урт хугацааны урьдчилсан тооцоолол хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, санал боловсруулах | | | | | | | | |
| 1.1.1 | Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/-ийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр батлагдсан дүрэм, журам, дээд газраас ирүүлсэн заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг зохион байгуулах. | Шаардлагагүй | Хэрэгжүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн тоо | Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой НДЕГ-аас 2023 онд ирүүлсэн 12 удаагийн зөвлөмжийн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан. | Дээд газраас ирүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж, үр дүнг тооцож ажилласан байна. | | 2024 оны 01 сарын 01-ны өдрөөс Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/-ийг хэрэгжүүлсэнтэй холбоотой шинээр батлагдсан хууль, дүрэм, журам, дээд газраас ирүүлсэн заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийг тухай бүр хэлтсийн албан хаагч ажилтнуудад танилцуулж, хэрэгжилтийг хангаж үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллаж байна. | 100 |

**ХОЁР. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ**

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Нийгмийн да... алын сангийн орлого бүрдүүлэх, тэтгэвэр, ... тэмж, төлбөр, зардлыг хугацаанд нь олго... р, авлага барагдуулах ажлыг удирд... зохион байгуулах, о...ийн харилцаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг зохион байгуулах, нийгмийн даатга... сангийн хуримтлал бий болгох, нэг... н бодох бүртгэлийн мэргэжил арга зүйгээр хангах, гүйцэтгэлийг тайлагнах | | | | | | | | |
| 2.1.1 | Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын төсвийн нарийвчилсан хуваарь, сар, улирлын хуваарийг мөрдөж ажиллах. | | Нийгмийн даатгалын сангийн 2024 оны орлого, зарлагын гүйцэтгэл | Нийгмийн даатгалын санд 2023 онд 165,855.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардалд 343,862.1 сая төгрөг зарцуулсан. | Батлагдсан төсвийн хуваарь, дээд газраас ирүүлсэн зөвлөмж, чиглэлийг мөрдөж ажилласан байна. | | 2024 оны жилийн эцсийн байдлаар түс газар нь нийгмийн даатгалын сангийн орлого 239032,4 сая төгрөгийн орлого хуримтлуулж, 454280,92 сая төгрөгийн зарлага гаргах төсөв батлагдсан. Сангийн орлогын төлөвлөгөөг 100 хувь биелүүлж, зардлыг батлагдсан хэмжээнээс хэтрүүлэлгүй 99,4 хувийн зарцуулалттайгаар, батлагдсан төсвийн хуваарийг баримтлан сангийн орлогыг бүрдүүлж, зарцуулалтад хяналт тавин ажилласан байна. | 100 |
| 2.1.2 | Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль, НДЕГ-ын даргын баталсан нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлын төсвийн нарийвчилсан хуваарь, сар, улирлын хуваарийг мөрдөж ажиллах. | | Нийгмийн даатгалын байгууллагын 2024 оны үйл ажиллагааны урсгал зардлын төсвийн гүйцэтгэл | Нийгмийн даатгалын байгууллагын 2023 оны үйл ажиллагааны урсгал зардалд 1679,4 сая төгрөг зарцуулсан. | Батлагдсан төсвийн хуваарь, дээд газраас ирүүлсэн зөвлөмж, чиглэлийг мөрдөж ажилласан байна. | | Байгууллагын үйл ажиллагааны урсгал зардал жилийн эцсийн байдлаар 2435,36 сая төгрөгийн төсөв батлагдаж, батлагдсан төсвийн хүрээнд хяналт тавин ажиллаж 97,8 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна. | 100 |
| 2.1.4 | ЭМДЕГ-аас ирүүлсэн эрүүл мэндийн даатгалын сангийн ажил олгогчийн шимтгэлийн орлогын төлөвлөгөөг жигд хангаж биелүүлэх. | | ЭМДЕГ-аас ирүүлсэн орлогын төлөвлөгөө биелсэн байна. | ЭМД-ын сангийн орлого 32772,3 сая төгрөг төвлөрүүлсэн. | ЭМД-ын сангийн орлогын төлөвлөгөө 100 хувь биелсэн байна. | | Ажил олгогчоос төлсөн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлогыг тухайн өдөр бүр төв сан руу төвлөрүүлж ажиллаж байна. Жилийн эцсийн байдлаар 37792,89 сая төгрөгийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлээд байна. | 100 |
| | Бусад өглөг, авлагыг барагдуулах | | Ажил олгогч, даатгуулагчийн шимтгэлийн өглөг авлагаас | Бусад өглөг авлага санхүүгийн тайлангаар | а) Нийгмийн даатгалын сангийн бусад өр, авлагыг оны | | а) Оны эхэнд бусад авлага 241,19 сая төгрөг байснаас жилийн эцсийн байдлаар өмнөх оны авлагаас 60,7 сая төгрөгийн авлагыг бууруулж | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.7 | | | бусад өглөг, авлагыг хугацаанд нь барагдуулна. | баталгаажсан байна. | эхний дүнгээс 50 хувиас доошгүй барагдуулах.<br>Б) Нийгмийн даатгалын байгууллагын бусад өр, авлагыг бүрэн барагдуулах. | | 201.89 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.<br>Оны эхэнд бусад өглөг 21.[illegible] сая төгрөг байснаас жилийн эцсийн байдлаар 4,83 сая төгрөгийн өглөгийг бууруулж ажилласан.<br>б) Жилийн эцсийн байгууллагын санхүүгийн тайлангаар өглөг, авлагын ямар нэгэн үлдэгдэлгүй гарсан. 2024 оны байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлын төсөв хангалттай хэмжээнд тавигдаагүй ч НДЕГ-руу төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах хүсэлтүүдийг хүргүүлж зарим нэг зардлыг шилжүүлэх замаар өр авлага үүсгэлгүй ажиллаж байна. ЗГ-ын 2024 оны 03 сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосоноос үүсч батлагдсан төсвөөс хэтрэлт үүсч даатгуулагчийн ндш-ийн 33.8 сая төгрөг, ажил олгогчийн ндш-ийн 4.4 сая төгрөг, мөн Гэрэл цахилгааны үнэ тариф нэмэгдэж, баянхошуу дахь нийгмийн даатгалын хэлтсийг том тогоогоор халааж байгаа гэх мэт асуудлаас үүссэн 13.1 сая төгрөгийн өглөг эхний хагас жилд үүссэнийг 2024 оны 9 дүгээр сард байгууллагын үйл ажиллагааны төсөвт тодотгол хийснээр өглөгөө хааж, жилийн эцсээр өглөг, авлага үүсгэлгүй ажиллалаа. | 70 |
| 2.1.8 | НДЕГ-ын даргын 2023.12.26-ны өдрийн А/183 тоот тушаалаар батлагдсан "Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх, хуваарилах, | | НДЕГ-ын төвлөрсөн орлогын харилцах дансанд өдөр бүр бүрэн төвлөрүүлнэ. | | НДЕГ-ын төвлөрсөн орлогын харилцах дансанд өдөр бүр бүрэн төвлөрүүлсэн байна. | | НДЕГ-ын даргын 2023.12.26-ны өдрийн А/183 тоот тушаалаар батлагдсан "Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх, хуваарилах, санхүүжилт олгох, хяналт тавих журам"-ын 3.3 дах заалтын дагуу өдөр бүр арилжааны 5 банк болон Төрийн сангийн | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | санхүүжилт олгох, хяналт тавих журам"-ын 3.3 дах заалтыг хэрэгжүүлж ажиллах. | | | | | | төвлөрсөн орлогын данс дах орлогыг төв сан руу төвлөрүүлж, жилийн эцсийн байдлаар 241 8,87 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлээд байна. | 100 |
| 2.1.9 | Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулах. | | Хууль тогтоомжийн дагуу иргэд даатгуулагчдад 436930,07 сая төгрөгийн тэтгэвэр тэтгэмж төлбөр зардлыг хугацаанд нь олгоно. | Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулсан. | а) Тэтгэврийг сар бүрийн 01-ний өдөр олгох<br>б) Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төсвийн дагуу 217221,89 сая төгрөгийг хуульд заасан хугацаанд зарцуулсан байна. | | а) Арилжааны банктай хамтран ажиллах гэрээний дагуу тус газар нь тэтгэвэр тавьж олгодог 4 арилжааны банк руу сар бүрийн ажлын сүүлийн өдрийн 10 цагаас өмнө тэтгэвэр тавьж олгох жагсаалтыг хүргүүлдэг. Мөн шинээр болон хугацаа сунгагдсан , өөрчлөлт орсон тэтгэвэр авагчийн жагсаалтыг тухай бүр банк руу явуулж тэтгэвэр олголтыг хугацаанд нь хийж байна.<br>б) Нийгмийн даатгалын сангийн 454280,92 сая төгрөгийн зардлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу жилийн эцсийн байдлаар батлагдсан хэмжээнээс хэтрүүлэлгүй 99,4 хувийн зарцуулалттай ажилласан байна.Үүнд: тэтгэврийн даатгалын сангаас 43977 иргэнд 410833,04 сая төгрөг, тэтгэмжийн даатгалын сангаас 7979 даатгуулагчид 22612,8 сая төгрөг, ҮОМШӨ-ны даатгалын сангаас 290 даатгуулагчид 3790,89 сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас 4122 даатгуулагчид 15018,0 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна. Өмнөх онуудтай харьцуулахад тэтгэмжийн сангийн зардал нэлээд өссөн. Энэ оноос тэтгэмжийн даатгалын сангийн жирэмсэн болон амаржсны тэтгэмжийг даатгуулагчийн харъяа дүүргээс өгдөг болсноор хүн ам ихтэй манай дүүргийн хувьд энэ төрлийн зардал авах даатгуулагчийн тоо нэлээд өссөн. Мөн ажилгүйдлийн даатгалын сангаас олгох | 100 |

5

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | тэтгэмжийн зардал жил бүр өсч байна. Эдгээр сангуудын зарлагын төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах саналыг тухай бүр дээд байгууллага руу хүргүүлж шийдвэрлүүлсэн. | |
| 2.1.10 | Батлагдсан зардлын төсөв, хөрөнгө оруулалтын зардлын үр ашгийг дээшлүүлж, хэмнэлтийн зарчмыг баримтлах. | | Батлагдсан төсвийг зардлын эдийн засгийн ангилал хооронд шилжүүлэн зарцуулахгүй, ажиллагсадтай холбоотой болон бусад өр авлагагүй ажиллана. | Батлагдсан 1722,8 сая төгрөгийн төсвийг зардлын ангиллын дагуу 1679,4 сая төгрөг зарцуулсан. | а)Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх.<br>б)Батлагдсан төсвийг зардлын ангиллын дагуу зарцуулах<br>в) Ажиллагсадтай холбоотой цалин, шимтгэл, татвар болон бусад өр авлага үүсгээгүй байна. | | Төсвийн хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлж батлагдсан төсвийн хүрээнд төсвийг зардлын ангиллын дагуу зарцуулж ажилласан. Байгууллагын үйл ажиллагааны зардлаас жилийн эцсийн байдлаар тээвэр шатахууны зардлыг 3.6 сая төгрөгөөр хэмнэж,. хэмнэсэн зардлыг төсөв хүрэлцэхгүй байгаа зардлууд руу хуваарилуулсан. Мөн Эрүүл мэндийн магадлах зөвлөлийн гишүүдийн ажлын хөлсөөс нийт 10.3 сая төгрөг хэмнэн, хэмнэсэн зардлаас төсөв хүрэлцэхгүй зардлын ангилал руу хувиарлуулсан. | 100 |
| 2.1.11 | Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын сангийн болон байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөх, төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, санхүүгийн тайлан гаргах ажлыг зохион байгуулах | | Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайланг үнэн зөв гаргаж, тогтоосон хугацаанд хүргүүлнэ. | Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, байгууллагын төсвийн гүйцэтгэлийн зарлагын мэдээ, сангийн өр | Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлийн тайлан, байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, байгууллагын төсвийн гүйцэтгэлийн зарлагын мэдээ, сангийн өр авлагын сарын | | Тайлант онд 12 сарын мэдээ, 1,2 дугаар улирлын үйл ажиллагааны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад цаг үеийн шаардлагатай мэдээ судлагааг тухай бүр хугацаанд нь үнэн зөв, чанартай гаргаж, холбогдох дээд шатны байгууллагууд руу хүргүүлж ажилласан. Шинэ системтэй холбоотой тайлангийн эхний үлдэгдэл, ажил олгогч, даатгуулагчдын үлдэгдэл тулган баталгаажуулалт, бусад системтэй холбоотой мэдээ, судалгаа, саналуудыг тухай бүр гаргаж ажилласан. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | авлагын сарын мэдээг гаргаж, хүргүүлсэн. | мэдээг үнэн зөв гаргаж, хугацаанд нь хүргүүлсэн байна. | | | |
| 2.1.12 | Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд шаардагдах эмч хөрөнгийн хэрэгцээ, захиран зарцуулалт, хадгалалт хамгаалалтыг төлөвлөх, хэрэгжүүлэх, ил тод тайлагнах. | | Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд шаардагдах эмч хөрөнгийн хэрэгцээ, захиран зарцуулалт, хадгалалт хамгаалалтыг төлөвлөн хэрэгжүүлж, тайлагнаж ажиллана. | Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд шаардагдах эмч хөрөнгийн хэрэгцээ, захиран зарцуулалт, хадгалалт хамгаалалтыг төлөвлөн хэрэгжүүлж, тайлагнасан байна. | -Үндсэн хөрөнгө актлах, шилжүүлэх үйл ажиллагааг хууль дүрэм, журамд нийцүүлэн өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлт, холбогдох баримтыг үндэслэн хөрөнгийн нэмэгдэх, хасагдах хөдлөлийг цаг тухай бүрд нь бүртгэлд тусгах; | | Жилийн эцсийн байдлаар үндсэн хөрөнгө актлах, шилжүүлэх үйл ажиллагааг хууль дүрэм, журамд нийцүүлэн өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлт, холбогдох баримтыг үндэслэн хөрөнгийн нэмэгдэх, хасагдах хөдлөлийг цаг тухай бүрд нь бүртгэлд тусгаж 31,66 сая төгрөгийн актлах хөрөнгийн жагсаалтыг гаргаж НДЕГ-т хүргүүлэн ажиллаж байна.<br>Эзэмшил газар, барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, үндсэн хөрөнгө г.м/ нэгдсэн судалгааны маягтууд ТӨХ /ТӨХ-1-с ТӨХ-11 маягт/ болон мэргэжлийн байгууллагад гаргаж өгдөг мэдээ тайланг хуулийн хугацаанд мэдээлэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын Тооллогын бүртгэлийн системд тооллогын мэдээллүүдийг оруулан тайланг хуулийн хугацаанд илгээсэн.<br>Тооллого болон бусад өмч хөрөнгөтэй холбоотой ажлуудыг тухай бүр Өмч хамгаалах байнгын зөвлөлөөр хэлэлцүүлэн өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад хяналт тавин ажиллаж байна. | 100 |
| 2.1.13 | Төсвийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж, Аудитын байгууллагаас "Өөрчлөлтгүй" дүгнэлттэй ажиллах. | | Өөрчлөлтгүй дүгнэлт авах, зөвлөмж, акт, албан шаардлагыг хугацаанд нь бүрэн биелүүлнэ. | А) Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлангийн Аудитын шалгалтаар өөрчлөлтгүй дүгнэлт авсан. | А) Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлангийн Аудитын шалгалтаар "Өөрчлөлтгүй" дүгнэлт авах. | | а) Тус газар нь 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлгүүлж ***ӨӨРЧЛӨЛТГҮЙ*** дүгнэлт авсан.<br>б) Санхүүгийн тайлангийн аудитын тайлангаар 5 зөвлөмж авсныг хуулийн дагуу 100 хувь хэрэгжилтийг хангаж ажиллах, зөвлөмжийг хэрэгжүүлж, аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийг | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Б) Санхүүгийн тайлангийн аудитын тайлангаар өгсөн залруулга, зөвлөмж, акт, албан шаардлагыг хэрэгжүүлсэн байна. | Б) Санхүүгийн тайлангийн аудитын тайлангаар өгсөн залруулга, зөвлөмж, акт, албан шаардлагыг 100.0 хувь биелүүлсэн байна. | | хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг нотлох баримтын хамт [illegible]сан хугацаанд хүргүүлэн ажилла[illegible]. | |
| 2.1.14 | Нийгмийн даатгалын ерөнхий газраас банкуудтай байгуулсан ерөнхий гэрээг хэрэгжүүлэх, дүгнэх, биелэлтийг НДЕГ-т хүргүүлэх. | | Нийгмийн даатгалын ерөнхий газраас арилжааны банкуудтай байгуулсан "Хамтран ажиллах гэрээ"-г хэрэгжүүлэн, хэрэгжилтийг дүгнэн НДЕГ-т хүргүүлнэ. | Банкуудтай байгуулсан ерөнхий гэрээний хэрэгжилтийг хангах ажилласан. | а) Банкуудтай байгуулсан ерөнхий гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллах.<br>б) Гэрээний хэрэгжилтийг дүгнэж, дүнг НДЕГ-т хүргүүлсэн байна. | | а) Харилцагч ХААН, ХАС, ХХБ, Төрийн банк, Голомт банкуудтай байгуулсан ерөнхий гэрээний хэрэгжилтийг заалт бүрээр хэрэгжүүлэн ажиллаж, шаардлагатай заалтууд дээр мэдээлэл , зөвлөгөө өгөх, уулзалт ярилцлага хийх байдлаар хамтран ажилласан.<br>b) 2024 онд харилцагч арилжааны банкуудтай байгуулсан гэрээний хэрэгжилтийг заалт тус бүрээр дүгнэж, дүнг цаашид гэрээнд тусгах санал хүсэлтийн хамт НДЕГ-руу хүргүүлэн ажиллаж байна. | 100 |
| 2.1.15 | Нийгмийн даатгалын сангийн цахим мэдээллийн санг тухай бүр үнэн зөв бүрдүүлэх. | | Холбогдох хууль тогтоомжийн дагуу мэдээллийг үнэн зөв оруулж бүртгэнэ. | Нийгмийн даатгалын сангийн мэдээллийн баазыг тогтоосон хугацаанд хаалт хийлгэсэн. | а) Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг цаг хугацаанд нь үнэн зөв бүртгэх ажлыг зохион байгуулж, бүртгэлийн алдаа, залруулга гаргахгүй байх.<br>Б) Ажил олгогч, даатгуулагчийн мэдээллийг үнэн зөв бүртгэж мэдээллийн сан | | 2024 оны 01 сарын 01-ны өдрөөс шинээр хэрэгжүүлж байгаа "Сикос" программ дээр мэдээллийг санг бүрдүүлж, анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг цаг хугацаанд нь үнэн зөв бүртгэх ажлыг зохион байгуулж, программтай холбоотой шинэчлэлүүдийг тухай бүр хэрэгжүүлж ажиллаж байна. Ажил олгогч байгууллагууд болон даатгуулагчдын төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийн төлбөр, даатгуулагчид олгож буй тэтгэвэр, тэтгэмж, төлбөр зардлыг | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | бүрдүүлсэн байна. | | даатгуулагч бүрээр тухай бүр үнэн зөв мэдээллийн санд [illegible]тэн оруулж байна. | |
| 2.1.16 | Нийгмийн даатгалын мэдээллийн систем хөгжүүлэх" төслийн хүрээнд Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн шинэчлэлтэй холбоотой ажлыг хэрэгжүүлэх. | | ХНХЯ-тай гэрээтэй Ай Ти Зон ХХК-ийн Төслийн багтай хамтран Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийг "Core" системээр хөтлөх ажлыг хийж гүйцэтгэнэ. | ХНХЯ-тай гэрээтэй Ай Ти Зон ХХК-ийн Төслийн багаас зохион байгуулсан ажлуудад оролцсон. | Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийг "Core" системээр хөтлөх ажлын гүйцэтгэлийг хангаж ажилласан байна. | | 2024 оны 01 сарын 01-ны өдрөөс шинээр хэрэгжүүлж байгаа "Сикос" программ дээр нягтлан бодох бүртгэлийг хөтөлж, өгсөн заавар чиглэлийн дагуу бүртгэл мэдээллийг оруулж, программ сайжруулалттай холбоотой саналуудыг өгч ажиллаж байна. | 100 |
| 2.1.17 | Нягтлан бодох бүртгэлийн тооцооны өглөг, авлагыг тооцоо нийлсэн актаар шинэчлэн баталгаажуулах | | Нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулна. | Тооцооны үлдэгдлийг баталгаажуулсан. | а) Нийгмийн даатгалын байгууллагын санхүүгийн тайлангийн тооцооны үлдэгдлийг эзэн холбогдогч бүрээр бүрэн шинэчлэн баталгаажуулах.<br>б) Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлангийн тооцооны үлдэгдлийг эзэн холбогдогч бүрээр бүрэн шинэчлэн баталгаажуулсан байна. | | Нийгмийн даатгалын сангийн болон байгууллагын нягтлан бодох бүртгэлийн тооцооны өглөг, авлагыг хариуцагч бүрээр шинэчлэн батлагаажуулж ажилласан.<br><br>ЗГ-ын 2024 оны 03 сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосоноос үүсч батлагдсан төсвөөс хэтрэлт үүсч даатгуулагчийн ндш-ийн 33.8 сая төгрөг, ажил олгогчийн ндш-ийн 4.4 сая төгрөг, мөн Гэрэл цахилгааны үнэ тариф нэмэгдэж, баянхошуу дахь нийгмийн даатгалын хэлтсийг том тогоогоор халааж байгаа гэх мэт асуудлаас үүссэн 13.1 сая төгрөгийн өглөг үүссэн санхүүгийн программд бүртгэж тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан. Жилийн эцсээр зарим зардлыг ангилал хооронд шилжүүлэх саналыг дээд газраа өгч шийдвэрлүүлсний дүнд өглөг авлага үүсгэлгүй ажилласан. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.18 | ЭМД-ийн шимтгэлээ өөрөө хариуцан төлдөг даатгуулагчтай холбоотой өглөг авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж ЭМДЕГ-т хүргүүлэхтэй холбоотой холбогдох ажлуудыг хэрэгжүүлэх | | Эрүүл мэндийн даатгалын сангийн харилцах дансуудыг хаах, харилцах дансны үлдэгдэл болон тайлангаар гарсан авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулна. | Харилцах дансны үлдэгдэл болон санхүүгийн тайлангаар баталгаажуулсан авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан | а) ЭМД-ын харилцах дансуудыг хаах, харилцах дансны үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.<br>б) Эрүүл мэндийн даатгалын авлага, өглөгийн тайлангийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулсан байна. 3903 дансны үлдэгдлийг даатгуулагч тус бүрээр жагсаалт үйлдэж НДЕГ-т ирүүлсэн байна.<br>в) 3303 дансанд бүртгэлтэй ЭМД-ын ташаарсан орлогыг жагсаалт үйлдэж тооцоо нийлж баталгаажуулан НДЕГ-т ирүүлнэ. | | а) Арилжааны 4 банк болон Төрийн санд байршиж байсан ЭМД-ын харилцах дансуудыг хааж, харилцах дансны үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан.<br><br>б) Эрүүл мэндийн даатгалын авлага, өглөгийн тайлангийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулсан. 2023 оны жилийн эцсийн тайлангаар 3903 дансны үлдэгдэлгүй даатгуулагч тус бүрээр ногдуулалт хийж батлагаажуулсан.<br><br>в) Өмнөх нягтлан бодох бүртгэлийн 3303 дансанд бүртгэлтэй ЭМД-ын 542620 төгрөгийн ташаарсан орлогыг 2024 оны 1 дүгээр сард багтааж залруулан, залруулга хийсэн жагсаалт үйлдэж тооцоо нийлж баталгаажуулан НДЕГ-т хүргүүлж ажилласан. | 100 |

## ДӨРӨВ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ

Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг судалж, хэрэгжилтийг хангах, төлөвлөх, тайлагнах, хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг оновчтой зохион байгуулах, нийгмийн даатгалын үйлчилгээг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1.1 | Нийгмийн даатгалын салбарын хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой гарсан тогтоол, тушаал шийдвэр болон | | Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, зөвлөмж, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн. | 2023 оны жилийн эцсийн байдлаар аймаг, нийслэлийн нийгмийн даатгалын хэлтсүүдэд | Өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь хэрэгжүүлж, биелэлтийг 06 сарын 20 дотор НДЕГ-ын | | Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, зөвлөмж, Засгийн газрын тогтоол, шийдвэр, Нийгмийн даатгалын салбарын хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой гарсан тогтоол, тушаал шийдвэр болон гүйцэтгэлийн төлөвлөгөөнд | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ, ажил үйлчилгээний хэрэгжилт, тайлан, дээд байгууллагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь хүргүүлэх. | | хэрэгжилт хангагдсан байна. | НДЕГ-аас өгсөн үүрэг даалгавар, тогтоол шийдвэр, чиглэл зөвлөмж, үйл ажиллагааны тайлан, зорилтот жилийн төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн авч дүгнэхэд нийт салбарын хэмжээнд хэрэгжилт 83,5%-тай хэрэгжсэн байна | Тамгын газарт хүргүүлнэ. | | тусгагдсан арга хэмжээ, ажил үйлчилгээний хэрэгжилт, тайлан, дээд байгууллагаас өгсөн үүрэг даалгаврын өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, биелэлтийг хугацаанд нь хүргүүлж ажилласан. | |
| 4.1.2 | ААНБ, иргэд, даатгуулагчдаас ирүүлсэн санал, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, үр дүнг хуулийн хугацаанд тайлагнах. | | Өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг хуулийн хугацаанд тайлагнасан байна. | Иргэд, байгууллагаас ирсэн санал, өргөдөл, гомдлыг шийдвэрлэлт 2023 онд 89,1 %-тай хэрэгжсэн байна. | Иргэд, даатгуулагч, ААНБ-аас ирсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд бүрэн барагдуулж, мэдээ үнэн бодит гаргаж улирал бүрийн сүүлийн сарын 20-ны дотор НДЕГ-ын Тамгын газарт хүргүүлнэ. | | Тус хэлтэст нийтдээ 155 албан бичиг, 513 өргөдөл гомдол ирснийг бүгдийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн. Өргөдөл гомдол шийдвэрлэх дундаж хугацаа ажлын 5 хоногт багтаан шийдвэрлэж байна. | 100 |
| 4.1.5 | Газрын дотоод ажлыг сайжруулах чиглэлээр тодорхой, шинэлэг ажил зохион байгуулах, тайланг хүргүүлэх | | Ажлын байр /албан тушаал/-ын тодорхойлолтоор заагдсан чиг үүргийг хэрэгжүүлсэн байна. | Газрын ажилтан, албан хаагчдын ажлын байрны чиг үүрэг тодорхой болсон байх. | Газрын дотоод ажлыг сайжруулсан, шинэлэг ажил үйлчилгээ нэвтрүүлсэн талаар тайланг 06 сарын 20, 12 сарын 20-ны дотор НДЕГ-ын Тамгын газарт хүргүүлнэ. | | 2024 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/-ийг хэрэгжүүлсэнтэй холбоотойгоор тус хэлтэс нь Нийгмийн даатгалын газар болж бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтүүд хийгдэж, газар болсонтой холбоотой байгууллагын нэр хаяг, тамга тэмдэг, харилцах дансны нэр зэргийг өөрчлөх ажлуудыг тухай бүр хийж гүйцэтгэсэн. Газрын дотоод ажлыг сайжруулах чиглэлээр зохион байгуулж байгаа | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | аклуудад идэвхи зүтгэлтэй оролцсон | |
| 4.1.7 | Газр[illegible] албан хаагчид авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх | | Авлигаас урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулсан байна. | Газрын ажилтнуудад авлигын тухай, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулах. | Газрын албан хаагчид авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх мэдлэг дээшилж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана. | | Газрын албан хаагчдад [illegible]лига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан сургалтанд идэвхитэй оролцож, мэдлэг мэдээллээ дээшлүүлж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаж байна. | 100 |
| 4.1.8 | Нийгмийн даатгалын газрын ажлын байрны болон үйлчилгээний стандартын хэрэгжилтийг хангаж ажиллах | | НДЕГ-ын 2016.12.07-ны өдрийн "Нийгмийн даатгалын байгууллагын байцаагч (ажилтан)-ийн үйлчлүүлэгчтэй харилцах журам" батлах тухай А/61 дүгээр тушаал, 2019.12.13-ны өдрийн "Нийгмийн даатгалын хэлтэс (тасаг)-ийн ажлын байр, үйлчилгээний орчны стандарт" батлах тухай А/194 дугаар тушаалын хэрэгжилтийг мөрдөж ажилласан байна | | Нийгмийн даатгалын газрын ажилтан албан хаагчдын харилцаа хандлагыг сайжруулж, ажлын байр, үйлчилгээний орчны стандарт хэрэгжилтийг хангаж ажилласан байна. | | Нийгмийн даатгалын газрын ажлын байрны болон үйлчилгээний стандартын хэрэгжилтийг хангаж ажиллаж , иргэд даатгуулагчид нийгмийн даатгалын шимтгэл төлөлт, даатгуулагчид олгож буй тэтгэвэр, тэтгэмжтэй холбоотой мэдээ мэдээллийг тухай бүр биечлэн хүргэж ажилласан. Хэлтсийн 70173260 дугаараар холбогдсон иргэдэд шаардлагатай мэдээллийг дуудлага алдалгүй хүргэж ажилласан. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1.10 | Төрийн албан хаагчийн хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргаж хэвших | | Хуулийн хугацаанд хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах | Хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд мэдүүлсэн. | Хөрөнгө орлогод орсон их хэмжээний өөрчлөлт болон ажил албан тушаал өөрчлөгдөх үед хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг тухай бүр гаргаж хэвшсэн байна. | | Төрийн албан хаагчийн хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргаж ажилласан. | 100 |
| 4.1.11 | Байгууллагын архивын баримтыг холбогдох хуулийн дагуу хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулах | | Холбогдох хуулиудыг мөрдөж ажиллах. | 214 хавтас баримтыг хүлээлгэн өгсөн. | Хөтлөх хэргийн жагсаалтад бүртгэлтэй архивын баримтыг стандартын дагуу баримтжуулж, хүлээлгэн өгсөн байна. | | 2023 оны санхүүгийн 214 хавтас баримтыг 1 дүгээр улиралд багтаан стандартын дагуу баримтжуулж, архивт хүлээлгэн өгсөн. 2024 оны анхан шатны баримтыг тухай бүр бүрдүүлж архивын нэгж болгон ажиллаж байна. | 100 |
| 4.1.12 | Төрийн албан хаагчийн хувийн хэргийг зохих журмын дагуу хөтлөх, баяжилтыг тухай бүр шинэчлэх | | Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журмыг хэрэгжилтийг хангах | Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 600 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам"-ын дагуу хувийн хэргийн баяжилт хийсэн. | Төрийн албан хаагчийн анкетыг шинэчилж, хувийн хэргийн баяжилтыг тухай бүр хийсэн байна. | | Төрийн албан хаагчийн анкетыг шинэчилж, хувийн хэргийн баяжилтыг тухай бүр хийсэн. | 100 |
| Нийгмийн даатгалын байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, олон нийт, харилцагч байгууллага салбар хэлтэс, тасгуудад мэдээлэл түгээх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах | | | | | | | | |
| 4.2.1 | Нийгмийн даатгалын байгууллагын ажилтны мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах; | | Хүний нөөцийг чадавхижуулах чиглэлээр зохион байгуулсан сургалтын тоо, | Албан хаагчдыг мэргэшүүлэх, ур чадварыг дээшлүүлэх 39 удаагийн сургалтад 809 | -Албан хаагчдыг мэргэшүүлэх, ур чадварыг дээшлүүлэх танхимын болон цахим сургалт | | Албан хаагчдыг ажил мэргэжлийн ур чадвар, харилцаа хандлагыг дээшлүүлж, иргэдэд нийгмийн даатгалын үйлчилгээг чирэгдэлгүй, хурдан шуурхай хүргэх зорилгоор хэлтсээс зохион байгуулсан | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хамруулсан хүний тоо | /давхардсан тоогоор/ албан хаагчийг хамруулсан. | зохион байгуулна. -Шинэ ажилтныг ажлын байран дээр дадлагажуулах сургалт зохион байгуулж, хөрвөх чадвар бүхий мэргэжилтэн бэлтгэнэ. | | сургалтанд хэлтсийн ажилтнуудыг идэвхитэй хамруулсан. 2024 оноос шинээр хэрэгжиж буй нийгмийн даатгалын багц хуулиудын өөрчлөлт, шинэчлэгдэн батлагдсан журамуудыг тухай бүр хэлтсийн албан хаагчдад танилцуулж, мэдээ мэдээллийг хүргэж ажилласан. Ажил олгогч, даатгуулагчдад чиглэсэн сургалт, сурталчилгаатай холбоотой зохион байгуулсан ажлуудын шаардлагатай төсвийн санхүүжилтийг батлагдсан төсвийн хүрээнд тухай бүр шийдвэрлэж ажилласан. | 100 |
| 4.2.2 | Ажил олгогч, даатгуулагч, малчин, албан бус хөдөлмөр эрхлэгч, оюутан сурагчид, тэтгэвэр тогтоолгох эрх нь үүсч буй иргэдэд нийгмийн даатгалын ач холбогдол, нийгмийн даатгалын тухай хуулиудад орсон өөрчлөлтүүдийн талаар сургалт зохион байгуулах | | Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх чиглэлээр зохион байгуулсан сургалтын тоо, хамрагдсан хүний тоо | Ажил олгогч, даатгуулагч, малчин, албан бус хөдөлмөр эрхлэгчид чиглэсэн 25 удаагийн сургалтад 2968 иргэд, даатгуулагчийг хамруулсан. | Сургалт зохион байгуулж, иргэд, даатгуулагчдын нийгмийн даатгалын талаарх мэдлэг, мэдээлэл дээшилж, хамралт нэмэгдсэн байна. | | Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулга, бусад багц хуулиудын өөрчлөлт, нийгмийн даатгалын шинэ системийн нэвтрүүлэлттэй холбоотой мэдээ мэдээлэл хүргэх зорилготой Ажил олгогчид зориулсан сургалт, зөвлөгөөнийг 2024 оны 5 дугаар сарын 1-ны өдөр болон 5 дугаар сарын 16-ны өдөр тус тус амжилттай зохион байгуулсан. | 100 |
| 4.2.3 | Нийгмийн даатгалын ач холбогдол, нийгмийн даатгалын тухай хуулиудад орсон өөрчлөлтүүдийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээгээр сурталчилах | | Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл, ач холбогдол, нийгмийн даатгалын үйлчилгээ, үйл ажиллагаа, цаг үеийн мэдээллийг сурталчлах зорилгоор орон нутгийн хэвлэл | Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээгээр сурталчилгаа хийсэн 98 тоо, мэдээллийн төрөл 5 мэдээллийн суваг:Эко тв, https://songinohairhan.ndaatgal.mn, facebook.com/Co | Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл, ач холбогдол, нийгмийн даатгалын үйлчилгээ, үйл ажиллагаа, цаг үеийн мэдээллийг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон | | Нийгмийн даатгалын ач холбогдол, нийгмийн даатгалын тухай хууль тогтоомж, үйлчилгээ, цаг үеийн мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээгээр өргөнөөр сурталчлах ажилд идэвхитэй оролцож хэлтсийн пэйж хуудас болон дээд шатны байгууллагын албан ёсны цахим хуудсаар дамжуулж буй мэдээ мэдээлэл, шторкыг цаг тухай бүрд нь иргэд, даатгуулагчдад түгээж ажилласан. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | мэдээллийн хэрэгслээр зохион байгуулсан арга хэмжээний тоо, төрөл, Нийгмийн сүлжээний хуудас (фэйсбүүк)-д байршуулсан мэдээллийн тоо, хандалтын тоо. Бэлтгэсэн нэвтрүүлэг, видео шторк, контент, цахим хичээл, постерын тоо. Иргэд, даатгуулагчид, ажил олгогчид, зорилтот бүлгүүд буюу хувиараа хөдөлмөр эрхлэгчид, малчдад чиглэсэн сурталчилгааны тоо, төрөл зохион байгуулсан арга хэмжээний тоо, төрөл | наанхавдрхан дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс | нийтийн сүлжээ болон бусад хэлбэрээр олон нийтэд ойлгомжтой, шуурхай хүргэсэн байна. ХНХЯ болон НДЕГ-аас бэлтгэсэн мэдээллийг бүх албан хаагчдаар цааш түгээлгэж, олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулсан байна. | | | |

ХОЁР. НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

| | Үүрэг даалгавар | Өгсөн субъект | Биелэлт |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |
| ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ | | | |
| 1.1.1. | **Арга хэмжээ.1** | | Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын 2025 оны төсвийн төсөл, 2026-2027 оны |

| | | | |
|---|---|---|---|
| | Нийгмийн даатгалын сангийн орлого, зар[illegible]тын 2025 оны төсвийн төсөл, 2026-202[illegible] оны төсөөлөл, байгууллагуудын үйл ажиллагааны урсгал зардал болон хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний 2025 оны төсвийн төсөл, 2026-2027 оны төсөөллийн саналыг НДЕГ-т тогтоосон хугацаанд хүргүүлэх | Газрын дарга | төсөөлөл, байгууллагуудын үйл ажиллагааны ур[illegible]л зардал болон хөрөнгө ор[illegible]алтаар хэр[illegible]жүүлэх төсөл, арга хэмжээний [illegible]25 оны төсвийн төсөл, 2026-2027 оны төсөөллийн саналыг дээд газраас ирсэн заавар чиглэлийн дагуу албан бичигт заасан хугацаанд холбогдох тооцоо судлагаанд суурилан үнэн зөв, чанартай гүйцэтгэж тогтоосон хугацаанд хүргүүлэн ажилласан. |
| 1.1.2 | Арга хэмжээ.2<br>"Шилэн дансны тухай" хуулийн хэрэгжилтийн хүрээнд байгууллагын болон нийгмийн даатгалын сангийн оруулбал зохих мэдээллүүдийг хуулийн хугацаанд үнэн зөв чанартай оруулах | Газрын дарга | "Шилэн дансны тухай" хуулийн хэрэгжилтийг хангаж байгууллагын болон нийгмийн даатгалын сангийн оруулбал зохих 135 мэдээллийг цаг хугацаанд нь үнэн зөв, шуурхай, бүрэн гүйцэт шилэн дансны цахим хуудсанд нээлттэй ил тод байршуулж ажилласан. |

## ГУРАВ. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Үр дүнгийн үзүүлэлт | |
|---|---|---|---|
| | | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт |
| 1 | 2 | 3 | 4 |
| "ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ, САЛБАРЫН ХУУЛЬ, ДАГАЛДАН ГАРСАН ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН МЭДЛЭГ ЧАДВАРЫГ ЭЗЭМШИХ, ТАСРАЛТГҮЙ ХӨГЖҮҮЛЭХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | |
| 1 | Арга хэмжээ 1. Монгол бичгийн анхан шатны мэдлэгийг бүрэн эзэмшиж уншиж, бичиж сурсан байна.<br>(МУЗГ-ын 2020 оны 96-р тогтоолын 3.2.15) | Монгол бичгээр уншиж , бичиж сурсан байна. | Монгол бичгийн анхан шатны мэдлэгээ сайжруулах зорилгоор хэлтсээс болон НДЕГ-аас зохион байгуулсан Үндэсний бичгийн анхан, дунд шатны сургалтанд амжилттай суралцан сертификат авч, цаашид ахисан түвшний сургалтанд хамрагдана. |
| 2 | Арга хэмжээ 2. Нийгмийн даатгалын байгууллагын ажилтны мэргэжлийн болон үйлчилгээний ур чадварыг дээшлүүлж, мэргэшүүлэх сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах | Хамрагдсан сургалтын тоогоор | Албан хаагчдад зориулсан цахим сургалтуудад идэвхитэй хамрагдаж, Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан "Үр дүнд суурилсан бодлого, төлөвлөлт, хяналт-шинжилгээ , үнэлгээ" цахим сургалт, мөн |

| | | | |
|---|---|---|---|
| | | | "7.4.10" цахим сургалтуудад амжилттай оролцсон. Нийгмийн даатгалын болон бусад хууль тогтоомж, журмуудыг тухай бүр судлаж, шинэчлэгдэн гарсан журам чиглэлийг тухай бүр танилцан холбогдох ажилтнуудад мэдээлэн ажиллаж байна. Тус хэлтсийн үйл ажиллагааны нягтлан бодогч Ц.Нарангарав Удирдлагын академийн Төрийн албаны сургуулийн төрийн албанд анх томилогдсон албан хаагчдад зориулсан дунд хугацааны сургалт, Сангийн нягтлан бодогч М.Тамир англи хэлний дунд шатны ярианы сургалтанд тус тус суралцаж байна. |
| 3 | Арга хэмжээ 3. Нягтлан бодох бүртгэлийн болон санхүү, татварын чиглэлээр цахим сургалт болон гарын авлага ашиглан суралцаж мэдлэг чадвараа дээшлүүлэх | Мэдлэг чадвар дээшилсэн байна. | Ай ти зон ХХК-аас зохион байгуулсан шинээр хэрэгжих байгууллагын санхүүгийн программыг танилцуулах сургалтанд идэвхитэй оролцсон. Мөн бие дааж нягтлан бодох бүртгэл, санхүү татварын чиглэлээр мэдлэгээ дээшлүүлсэн. |